ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЭР, БЭЛГИЙН ЦОГЦ БОЛОВСРОЛЫН АГУУЛГЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

(СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР)

Улаанбаатар хот
2025 он

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХҮНИЙ ЭРХ, ЖЕНДЭР, БЭЛГИЙН ЦОГЦ БОЛОВСРОЛЫН АГУУЛГЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ (СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР)

Шинжээч Б.Уранзаяа (Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийг хөтөлбөрийн ажилтан, Бэлгийн цогц боловсролын үндэсний сургагч багш)

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот
2025 он

ТАНИЛЦУУЛГА

Хөтөлбөрийн баримт бичигт хүний эрх, жендэрийн тэгш байдал, бэлгийн цогц боловсрол (БЦБ)-ын суурь ойлголтууд тусгагдсан хэдий ч эдгээр агуулгыг:

- Үр дүнтэй хэрэгжихүйц,
- Хичээл хоорондын уялдаа холбоотой байх,
- багш, эцэг эхэд ойлгомжтой байх

гэсэн шаардлагын дагуу “бүрэн цогц боловсруулаагүй” гэж үзэж байна.

Иймд хөтөлбөрийн хэрэгжилтийн чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор дараах зөвлөмжийг, жишиг хичээлийн төлөвлөгөөг боловсруулав.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Сэдэв	Илэрсэн байдал /тусгагдсан агуулга/	Орхигдуулсан байдал	Давуу тал	Сул тал	Боломжит үр дагавар
Хүний эрхийн боловсрол	Нийтлэг үндэслэл хэсэгт хүний эрх, эрх чөлөө, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх үнэт зүйлийг тодорхой тусгасан. **Нийтлэг агуулгын хүрээ Хүний эрхийн боловсрол хэсэгт:** • Хүүхэд өөрийн эрхийг мэдэх • Ялгаварлан гадуурхахгүй байх • Өөрийн болон бусдын эрхийг хамгаалах талаар дүрд тоглох, төсөлд оролцох **Нийгэм-сэтгэл хөдлөл, Байгаль-нийгмийн орчин чиглэлд:** • Бусдын ялгаатай байдлыг таних • Хүндэтгэлтэй харилцах • Эрх тэгш оролцох хандлагыг төлөвшүүлэх чадамжууд тусгагдсан.	Хүний эрхийн ойлголт чадамжийн түвшинд тодорхой боловч: Сургалтын агуулга, үйл ажиллагааны жишээ Насанд тохирсон бодит кейс, нөхцөл байдал Багшид зориулсан арга зүйн нарийвчилсан заавар дутмаг. “Өөрийн эрхийг хамгаалах” ойлголтыг ямар үйлдлээр, ямар нөхцөлд илэрхийлэхийг задалж өгөөгүй.	Хүүхдийг бага наснаас нь: өөрийгөө үнэлэх, бусдыг хүндэтгэх, ялгаварлалгүй харилцах суурь хандлагад сургах боломж бүрдсэн. Олон улсын хүний эрхийн боловсролын чиг хандлагатай нийцсэн.	Хийсвэр, ерөнхий түвшинд үлдсэн. Багш бүр өөрийн ойлголтоор хэрэгжүүлэх эрсдэлтэй. Хүүхдийн бодит амьдралтай холбох гүүр сул.	**Эерэг:** Хүүхдийн өөртөө итгэх итгэл нэмэгдэнэ Ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх соёл төлөвшинө **Сөрөг:** Бодит амьдрал дээр өөрийгөө хамгаалах чадвар сул үлдэж болзошгүй Эрх зөрчигдөх үед яах ёстойгоо тодорхой мэдэхгүй байх эрсдэлтэй

Жендэр	Нийтлэг агуулгын хүрээ Жендэрийн эрх тэгш байдал хэсэгт:	Жендэрийн агуулга:	Хүүхдэд жендэрийн суурь ойлголтыг эртнээс өгөх боломжтой.	Жендэрийг “тусдаа хэсэг” мэт авч үзсэн.	Эерэг:
	Хүйсээр ялгаварлахгүй байх Охид, хөвгүүд ижил үүрэгтэй тоглох Хүүхэд сонирхлоороо тоглоом, ном сонгох **Чадамжийн хүрээ-д** жендэрийн эрх тэгш байдлын ойлголт тодорхой орсон.	Сургалтын чиглэл бүрийн агуулгад системтэй шингээгүй (математик, хэл яриа, урлаг, хөгжим гэх мэт) Жендэрийн хэвшмэл ойлголтыг задлан шүүмжлэх, альтернатив жишээ өгөхгүй. Багшид зориулсан “юуг анхаарах, юунаас зайлсхийх” заавар дутуу	Тоглоом, дүрд тоглох аргаар дамжуулан ялгаварлалгүй хандлага төлөвшүүлэх нөхцөл бүрдсэн.	Өдөр тутмын сургалт, харилцаанд бодитоор хэрэгжих баталгаа сул.	Хүүхэд өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх Мэргэжил, сонирхлыг хүйсээр хязгаарлахгүй хандлага төлөвших **Сөрөг:** Жендэрийн хэвшмэл ойлголт (охид – гүнж, хөвгүүд – баатар гэх мэт) хэвээр үлдэх Багшийн далд ялгаварлалаар агуулга гажих эрсдэлтэй

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Бэлгийн цогц боловсрол	**Хөдөлгөөн, эрүүл мэнд** чиглэлд: "Миний биеийн аюулгүйн дүрэм" Өөрийн болон бусдын хүрч болохгүй хэсгийг ялгах "Үгүй" гэж хэлж өөрийгөө хамгаалах Хувийн аюулгүй байдлын дүрэм Насанд тохирсон, хамгаалах чиглэлийн агуулга орсон нь чухал ахиц.	**БЦБ нь:** Эрүүл мэндийн хүрээнд хязгаарлагдсан Нийгэм-сэтгэл хөдлөл, хүний эрхтэй уялдаагүй "Бие эрхтний нэршил"-ийг зөв, нээлттэй хэрэглэх талаар тодорхой тусгаагүй. Эцэг эхэд чиглэсэн мэдээлэл, оролцооны механизм сул.	Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах суурь мэдлэг олгоно. Насны онцлогт нийцсэн, айдас төрүүлэхгүй байдлаар тусгасан.	"Цогц" шинж хангалтгүй Харилцаа, зөвшөөрөл, хувийн орон зай, итгэлцэл зэрэг ойлголт дутуу.	**Эерэг:** Хүүхэд өөрийгөө хамгаалах чадвартай болно Хүчирхийллийн эрсдэл буурна **Сөрөг:** Хүүхэд биеийн аюулгүй байдлыг "дүрэм" төдий ойлгоод, яагаад, хэнд, хэрхэн хандахаа бүрэн ойлгохгүй үлдэж магадгүй

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Агуулгын түвшинд

Хүний эрх, жендэр, БЦБ-ыг бүх сургалтын чиглэлд уялдуулан тусгах. Тухайлбал:

- Математик: охид, хөвгүүдийн тэгш оролцоотой жишээ
- Хэл яриа: ялгаатай байдал, зөвшөөрлийн тухай зохиол
- Урлаг: өөрийгөө илэрхийлэх, биеийн хил хязгаар

2. Арга зүйн түвшинд

Багшид зориулсан:

- тодорхой тоглоомын жишээ
- асуулт–хариултын загвар
- анхаарах эрсдэл (жендэрийн хэвшмэл хэллэг, шошголол)

3. Багш, эцэг эхийн хамтын ажиллагаа

Эцэг эхэд зориулсан:

- товч гарын авлага
- хэлэлцүүлгийн сэдэв
- гэртээ давтах энгийн үйл ажиллагаа
- “Хэрхэн хамтрах вэ?” гэдгийг алхамчилж тодорхойлох.

4. БЦБ-ын хүрээнд

- Бие эрхтний нэршлийг насанд тохирсон, шинжлэх ухааны зөв нэрээр хэрэглэх

“Миний бие – минийх” ойлголтыг хүний эрхтэй уялдуулах

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ЗАГВАР ХИЧЭЭЛ

1. МИНИЙ БИЕИЙН ТУХАЙ

Зорилго

Хүүхдүүдэд хүний биеийн онцлог, эрхтэн болон онцгой байдлын тухай ойлгуулна.

Түлхүүр үг: Бие эрхтэн

Зорилт

1. Бие эрхтнийг ялгаж, нэрлэж сурна.
2. Өөрийн бие эрхтний онцлог ялгааг мэдэж, бусад хүмүүс хүрч болох, болохгүй хэсгийг ялгаж танина. / ХЭМ2.2д./

Хугацаа: 20 минут /үйл ажиллагаа тус бүр/

Алхамчилсан явц

Алхам 1. Сэдэлжүүлэлт – Багшийн мэндчилгээ (5 минут)

Хэрэглэгдэхүүн: Эрэгтэй, эмэгтэй хүний биеийг харуулсан **зураг.**

Багшийн хэлэх үг:

"Сайн байна уу, хүүхдүүд ээ. Өнөөдөр бид маш сонирхолтой сэдвийн талаар ярилцана.

Та нар өөрсдийнхөө биеийн тухай юу юу мэддэг вэ?"

Хүүхдүүдээс гарч болох боломжит хариулт:

- "Гартай, хөлтэй, нүдтэй, алхдаг, хардаг, иддэг" гэх мэт

Багшийн чиглүүлэг:

"Тийм ээ, маш сайн байна. Бид бүгд өөрсдийн гэсэн биетэй, бие маань бидэнд олон зүйл хийхэд тусалдаг."

Анхаарах зүйл:

- Бүх хариултыг зөвшөөрч, засахгүй
- Хүүхдийг ичээх, шоолохгүй

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Алхам 2. Шинэ мэдлэг олгох – Биеийн эрхтнүүд (7 минут)

Багшийн тайлбар:

"Бүгдээрээ одоо хүний биеийн хэсгүүдээр зочилж, танилцацгаая. Энэ бол хүний биеийн хэсгүүд."

(Хүний нүүрэнд байдаг эрхтнүүдийг зургаар харуулна.)

"Хүн бүр өөр өөр нүдтэй, чихтэй, хамартай байгаа биз. Гэхдээ бүгдээрээ хөөрхөн, хүний биеийн бүх эрхтэн маш чухал."

Эрхтний үүргийг тайлбарлах:

"Бидний чих сонсоход тусалдаг. Бидний ам идэх болон ярихад хэрэгтэй. Нүд харахад, хамар үнэрлэхэд тусалдаг."

Багш үргэлжлүүлэн:

“Энэ бол гар, харин энэ бол хөл. Бид гараараа юм барьж, хүрч, тоглодог. Хөлөөрөө алхаж, гүйдэг. Биеийн хэсэг бүр өөр өөрийн үүргийг гүйцэтгэдэг.”

Багшийн асуулт:

- Гараараа юу хийдэг вэ?
- Хөлөөрөө яадаг вэ?

Хүүхдүүдээс гарч болох хариулт:

- Гараараа тоглодог
- Хөлөөрөө гүйдэг
- Нүдээрээ хардаг

Анхаарах зүйл:

- Хүүхдийн хэлсэн үгийг давтаж баталгаажуулах
- Энгийн, ойлгомжтой үг ашиглах

Алхам 3. Хувийн, нууц хэсгийн ойлголт (5 минут)

Багшийн хэлэх үг:

“Зарим биеийн хэсгийг бид хувийн, нууц хэсэг гэж нэрлэдэг. Эдгээр хэсгийг бусад хүмүүст харуулж, хүргэж болдоггүй.”

(Охин, хүүгийн биеийн зургийг харуулна.)

Багш тайлбарлана:

“Энэ бол охины бие, харин энэ бол хүүгийн бие. Охид том болохоор цээжний хэсэг томорч, хөх ургадаг. Энэ бол охидын нууц хэсэг юм. Хэн нэгэн чиний энэ хэсэгт хүрч яагаад ч болохгүй.”

“Хөвгүүдэд шодой байдаг. Шодойгоор шээс гардаг.” (Энэ үед бэлэг эрхтний нэршлийг ичээлгүй, зөвөөр хэлж сургахад анхаарна.)

“Энэ бол охины бэлэг эрхтэн. Охид сууж бие засдаг. Охид, хөвгүүдийн бэлэг эрхтэн өөр учраас бие засахдаа өөр өөр байдлаар бие засдаг. Бидний өгзөг ч мөн хувийн, нууц хэсэг. Тиймээс бид дотуур хувцас заавал өмсдөг.”

Багшийн асуулт:

- Хэрвээ хэн нэгэн чиний нууц хэсэгт хүрвэл яах вэ?

Хүүхдүүдээс гарч болох хариулт:

- Том хүнд хэлнэ

Анхаарах зүйл:

- Айдас төрүүлэхгүй
- “Чи буруугүй” гэдгийг ойлгуулах

Алхам 4. Бататгах үйл ажиллагаа (5 минут)

Багшийн асуулт:

“Хэрвээ хэн нэгэн чиний биеийн аль нэг хэсэгт хүрэхэд чамд эвгүй санагдвал яах вэ?”

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хүүхдүүдийн боломжит хариулт:

- Үгүй гэж хэлнэ
- Багшдаа хэлнэ
- Ээж, аавдаа хэлнэ

Багш бататгана:

- Тийм ээ. Үгүй гэж хэлэх нь зөв. Том хүнд хэлэх нь маш зөв.
-

Алхам 5. Дүгнэлт, үнэлгээ (3 минут)

Багшийн асуулт:

- Өнөөдөр бид юу сурсан бэ?

Хүүхдүүдийн боломжит хариулт:

- Биеэ хамгаалах
- Хүн бүр өөр
- Үгүй гэж хэлж болно

Багшийн дүгнэлт:

- Та нар маш сайн байлаа. Өөрийнхөө биеийг мэдэх, хамгаалах нь маш чухал шүү.

Асран хамгаалагчийн оролцоо

Асран хамгаалагчид өгөх товч мэдээлэл:

Хүндэт эцэг эх, асран хамгаалагч танаа,
Энэ долоо хоногт хүүхдүүд өөрийн биеийн хэсгүүд, тэдгээрийн үүрэг, хувийн (нууц) хэсгийн тухай насанд нь тохируулан ярилцсан.

Энэ нь хүүхдийг:

- өөрийн биеэ хүндэтгэх,
- бусдын биеийг хүндлэх,
- өөрийгөө хамгаалах суурь ойлголттой болгох зорилготой.

Биеийн тухай ярих нь хүүхдийн аюулгүй байдал, өөртөө итгэх итгэлийг дэмждэг.

Асран хамгаалагч–хүүхдийн гэрийн даалгавар:

Даалгавар 1. “Миний бие” яриа (5–10 минут)

Хүүхдээсээ дараах асуултыг асуугаарай:

- Чиний биеийн ямар ямар хэсгүүд байна вэ?
- Аль хэсгийг бид хувийн, нууц хэсэг гэдэг вэ?
- Яагаад эдгээр хэсгийг хамгаалах ёстой вэ?

Хүүхдийн хариуг засах гэж яаралгүй, сонсож, бататгаж өгнө.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Даалгавар 2. “Миний бие – минийх”

Хүүхдэд энгийнээр тайлбарлаарай:

“Чиний бие бол чинийх. Чамд эвгүй, тухгүй санагдвал ‘үгүй’ гэж хэлэх эрхтэй.”

Анхааруулах зүйл:

- Инээж шоолох, ичээх үг бүү хэрэглэ
- Биеийн хэсгийг жинхэнэ нэрээр, энгийнээр хэлж хэвшээрэй
- “Болохгүй” гэдгийг айдасгүйгээр тайлбарлаарай

2. МИНИЙ БИЕИЙН АЮУЛГҮЙН ДҮРЭМ

Хугацаа:
20 минут /үйл ажиллагаа тус бүр/

Зорилго

Хүүхдүүдэд өөрийн аюулгүй байдлыг хамгаалах буюу биеийн аюулгүй дүрмийн тухай ойлгуулна.

Зорилт

1. Өөрийн болон бусдын биеийн хүрч болохгүй хэсгийг ялгаж, шаардлагатай үед “Үгүй” гэж хэлж өөрийгөө хамгаална. /ХЭМ3.2д./
2. Өөрийгөө хамгаалах дадалд суралцана.

Хэрэглэгдэхүүн:
Эрэгтэй, эмэгтэй хүний биеийг харуулсан зураг.
Улаан, шар, ногоон өнгийн наалтууд

Алхамчилсан явц

Алхам 1. Сэдэлжүүлэлт, яриа (5 минут)

Багшийн хэлэх үг:

- Сайн байна уу, хүүхдүүд ээ. Өнөөдөр бид өөрсдийн биеэ хэрхэн аюулгүй байлгах талаар ярилцана.

Багш асуулт асууна:

- Одоо бүгдээрээ охид, хөвгүүдэд байдаг ижил биеийн хэсгүүдийн талаар ярилцах уу? Та нар юу гэж бодож байна, бидэнд өөр өөр хэсгүүд байдаг ч ижил хэсгүүд бас бий юу?

Хүүхдүүдээс гарч болох хариулт:

- Гар, толгой, хөл, нүд

Багшийн чиглүүлэг:

- Тийм ээ, зөв байна. Охид, хөвгүүд өөр өөр ч гэсэн ижил биеийн хэсгүүд олон байдаг.

Анхаарах зүйл:

- Охид, хөвгүүдийг ялгаварлахгүй
- “Бүгд адилхан үнэ цэнтэй” гэдгийг мэдрүүлэх

UIH MN
СУДАЛГААНЫ САН

Алхам 2. Тайлбар – Биеийн аюулгүй байдал (5 минут)

Ашиглаж болох материал:
Сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдүүдэд бэлгийн боловсрол олгох VR хичээл:

Цахим бичлэг:
Сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдүүдэд бэлгийн боловсрол олгох VR хичээл

Багшийн тайлбар:

- Биеийн зарим хэсгийг бид хүмүүсийн нүднээс нуух хэрэгтэй байдаг. Эдгээрийг биеийн далд, хувийн хэсэг гэж нэрлэдэг.

Багш тодорхойлно:

- Үүнд бэлэг эрхтэн, өгзөг, цээж орно. Охид, хөвгүүд адилхан. Эдгээр хэсгийг бид хамгаалах хэрэгтэй.

Багш үргэлжлүүлнэ:

- Хэрвээ хэн нэгэн чиний биеийн хувийн, далд хэсгийг харахыг хүсвэл чи татгалзах ёстой. Зөвшөөрч болохгүй. Зөвхөн ээж нь/чамайг асарч байгаа том хүн усанд оруулах үед, эсвэл эмч биеийг нь үзэх үед л харж болно. Энэ үед заавал зөвшөөрөлтэй байна.

Нэмэлт чухал ойлголт:

- Бид биеийн нууц хэсгүүдээ хувцсаар халхалдаг. Тиймээс дотуур хувцсаа байнга өмсөх хэрэгтэй.
- Ариун цэврийн өрөө орохдоо хаалгаа заавал хаагаарай.
- Хэн нэгэн чиний зургийг зөвшөөрөлгүй дарж болохгүй. Ялангуяа хувцасгүй үед чинь энэ огт хориотой."

Багш асуулт асууна:

- Яагаад ингэж хамгаалах хэрэгтэй вэ? (Хүүхдүүдийн хариуг чөлөөтэй сонсоно.)

Анхаарах зүйл:

- Айдас төрүүлэхгүй
- "Чи буруугүй, чи өөрийгөө хамгаалж чадна" гэдгийг ойлгуулах

Алхам 3. Ёс зүй, харилцаа (3 минут)

Багш асуулт асууна:

- Хэн нэгэн чамд гомдоох үг хэлж байсан уу?
- Чамд тэр үед ямар мэдрэмж төрсөн бэ?

Багш тайлбарлана:

- Хэн нэгнийг муухай үгээр хэлэх, зодох, гэмтээх, дээрэлхэх нь маш муухай зүйл. Хэрвээ хэн нэгэн чамд таагүй үг хэлэх, гомдоох, цохих зэрэг үйлдэл хийвэл чи үүний эсрэг байж өөрийгөө илэрхийлэх хэрэгтэй. Бусдаас тусламж хүсэх нь огт ичих зүйл биш.

Анхаарах зүйл:

- Хүүхдийг буруутгахгүй
- Сэтгэл хөдлөлийг зөвшөөрч, хүлээн зөвшөөрөх

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Алхам 4. Тоглоом – "Гэрлэн дохио" (5 минут)

Багш асуулт асууна:

- Гэрлэн дохио ямар ямар өнгөтэй билээ?

Хүүхдүүдийн хариу:

- Улаан, шар, ногоон

Багш тайлбарлана:

- Улаан – Хүрч БОЛОХГҮЙ
- Ногоон – Хүрч БОЛНО (гэхдээ эвгүй байвал "Үгүй" гэж хэлнэ)

Үйл ажиллагаа:

- Хүний биеийг харуулсан зураг дээр
- Улаан наалтыг хүрч болохгүй хэсэгт
- Ногоон наалтыг хүрч болно гэж бодсон хэсэгт хүүхдүүдээр наалгана

Дараах ярилцлага:

- Яагаад ингэж наасан бэ?

Багшийн чухал тайлбар:

- Заримдаа гар хүрч болдог мэт санагддаг.Гэхдээ хэрвээ гар байсан ч чамд эвгүй санагдвал чи 'Үгүй' гэж хэлэх эрхтэй."

Алхам 5. Дүгнэлт, бататгал (2 минут)

Багшийн асуулт:

- Чамд ямар нэгэн таагүй зүйл тохиолдвол чи хэнд хэлж болох вэ?

Хүүхдүүдээс:

- Итгэдэг 3 хүнийг нэрлүүлнэ

Багш дүгнэнэ:

- Итгэдэг хүндээ хэлэх нь чиний өөрийгөө хамгаалж байгаа нэг хэлбэр юм.

Эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо

Асран хамгаалагчид өгөх товч мэдээлэл:

Хүүхдүүд цэцэрлэг дээр:

- биеийн аюулгүй байдлын дүрэм
- хүрч болох / болохгүй нөхцөл
- "Үгүй" гэж хэлэх, тусламж хүсэх тухай ярилцсан. Энэ нь хүүхдийг эрсдэлээс хамгаалах, дуугарч сурахад чиглэнэ.

Гэрийн даалгавар

- Хүүхэдтэйгээ хамт "итгэдэг хүмүүсийн жагсаалт" гаргах (3–5 хүн)
- Гэртээ "Үгүй гэж хэлэх" жижиг дүрд тоглох Жишээ: "Хэрвээ хэн нэгэн чамд эвгүй санагдуулахад яах вэ?"
- Хүүхдийн яриаг шүүмжлэхгүй, анхааралтай сонсох

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

3.ЖЕНДЭР

Зорилго

Энэхүү агуулгын хүрээнд охид болон хөвгүүдийн тухай ойлголтыг энгийн аргаар тайлбарлах бөгөөд жендэрийн мэдрэмжийг энгийнээр ойлгуулах.

Зорилт

1. Охид болон хөвгүүдийн ойлголт нэмэгдэх.
2. Ялгаатай байдлыг ойлгох

Хугацаа:
20 минут /үйл ажиллагаа тус бүр/

Хэрэглэгдэхүүн:

Эрэгтэй, эмэгтэй хүний биеийг харуулсан зураг.

Олон төрлийн хувцасны зураг / улс, үндэстнүдийн уламжлалт хувцас/

Олон төрлийн мэргэжлүүдийг дүрсэлсэн зураг, тоглоом

Спортуудын төрлийг харуулсан зураг, тоглоом

Янз бүрийн сэтгэл хөдлөлүүдийг харуулсан зураг

Алхамчилсан явц

Алхам 1. Сэдэлжүүлэлт – Танилцах яриа (5 минут)
Багшийн асуулт:

- Энэ ямар хүүхэд байна вэ? Охин уу, хүү юу? (Охид, хөвгүүдийн зургийг харуулна.)

Хүүхдүүдээс гарч болох хариулт:

- Охин
- Хүү

Багш асуултаа үргэлжлүүлнэ:

- Яагаад охин гэж бодсон бэ?
- Яагаад хүү гэж бодсон бэ?

Хүүхдүүдийн боломжит хариу:

- Үс нь урт
- Хувцас нь өөр
- Царай нь өөр

Багшийн чиглүүлэг:

- Тийм ээ, охид, хөвгүүд гадаад төрхөөрөө ялгаатай байж болно.

Анхаарах зүйл:

- “Зөв/буруу” гэж дүгнэхгүй
- Хүүхдийн бодлыг чөлөөтэй илэрхийлүүлэх

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Алхам 2. Бие махбодын ялгааг ойлгуулах (5 минут)
Багшийн тайлбар:

- Охид, хөвгүүдийн бие махбод өөр өөр байдаг.

Тодорхой тайлбар:

- Хөвгүүд шодойтой байдаг. Охид үтрээтэй байдаг. Эдгээр нь бидний эмзэг, хувийн хэсэг юм.
- Энэ хэсэгт ээж /чамайг асарч байгаа том, итгэлт хүн/ чинь өөр хэн ч хүрч болохгүй.
- Мөн бусдад харуулж болдоггүй.

Багш нэмнэ:

- Хөвгүүд ихэвчлэн босож шээдэг. Охид сууж шээдэг. Гэхдээ хөвгүүд ч сууж шээж болно.

Анхаарах зүйл:

- Айдас төрүүлэхгүй
- Эрхтний нэршлийг зөв, ичээлгүй хэлэх

Алхам 3. Хувцас, соёлын ялгааг ойлгуулах (4 минут)
Багш асуулт асууна:

- Бид цагаан сараар юу өмсдөг вэ?

Хүүхдүүд:

- Дээл

Багш тайлбарлана:

- Дээл гоё юу? Тийм ээ. Бидэнд гоё санагддаг. Бусад улсад хөвгүүд юбка өмсдөг улс ч байдаг.

Багш дүгнэнэ:

- Охид, хөвгүүд хэн нь ч юу ч өмсөж болдог. Хувцас хүнийг охин, хүү болгодоггүй.

Алхам 4. Сэтгэл хөдлөл ба зан чанар (4 минут)
Багш асуулт асууна:

- Охид уйлж болдог уу?
- Хөвгүүд уйлж болдог уу?"

Хүүхдүүдийн хариуг сонсоод багш тайлбарлана:

- Охид, хөвгүүд хэн нь ч уйлж болно.
- Айж болно.
- Баярлаж болно.
- Уурлаж болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Жишээ тайлбар:

- Хөвгүүд аймхай байж болно.
- Охид хүчирхэг байж болно.
- Энэ бүхэн хэвийн.

Анхаарах зүйл:

- Хэвшмэл ойлголт үүсгэхгүй
- Сэтгэл хөдлөлийг зөвшөөрөх

Алхам 5. Тоглоом, ажил мэргэжлийн тухай ойлголт (4 минут)
Багш асуулт асууна:

- Охид хөлбөмбөг тоглож болох уу?
- Хөвгүүд хүүхэлдэйгээр тоглож болох уу?

Багш тайлбарлана:

- Охин ч байсан, хүү ч байсан ямар ч тоглоомоор тоглож болно.
- Гэрийн ажлыг хэн ч хийж чадна. Ээж тог засаж болно. Аав хоол хийж болно.

Мэргэжлийн жишээ:

- Охид ч, хөвгүүд ч жолооч, гал сөнөөгч, эмч, тогооч, барилгачин, хуульч ямар ч ажил хийж чадна.

Алхам 6. Найз нөхөрлөл (2 минут)
Багш асуулт:

- Охид, хөвгүүд найзалж болох уу?

Багш дүгнэнэ:

- Охид, хөвгүүд хоорондоо найзалж болно. Бие биедээ тусалж, хүндэлж байх ёстой.

Дүгнэлт (2 минут)
Багшийн асуулт:

- Өнөөдөр бид юу сурсан бэ?

Хүүхдүүдийн боломжит хариу:

- Бүгд өөр
- Бүгд чадна
- Охид, хөвгүүд адилхан

Багшийн дүгнэлт:

- Охид, хөвгүүд ялгаатай ч бүгд адилхан үнэ цэнтэй.

Эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо

Асран хамгаалагчид өгөх товч мэдээлэл:

Энэ сэдвээр хүүхдүүд:

- охид, хөвгүүд ялгаатай ч адилхан үнэ цэнтэй
- тоглоом, мэргэжил, сэтгэл хөдлөлд хүйс хамаарахгүй гэдгийг ярилцсан.

Даалгавар 1. “Манай гэр бүл”
Хүүхэдтэйгээ ярилцаарай:

- Манай гэрт хэн юу хийж чаддаг вэ?
- Аав хоол хийж чадах уу?
- Ээж машин барьж чадах уу?

Үлгэрлэн харуулах нь хамгийн сайн сургалт.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Даалгавар 2. Тоглоомын чөлөөт сонголт

- Хүүхдэд “энэ бол охидын/хөвгүүдийн тоглоом” гэж бүү хязгаарла
- Хүүхдийн сонирхлыг дэмж

Эцэг эхэд анхаарах

- “Хөвгүүд уйлдаггүй”, “Охид тийм байж болохгүй” гэх үгсээс зайлсхий
- Сэтгэл хөдлөл илэрхийлэх нь хүн бүрт зөвшөөрөгдсөн

4.ЯЛГААТАЙ БАЙДАЛ

Хугацаа:
20 минут /үйл ажиллагаа тус бүр/

Зорилго

Хүүхэд, хүн бүрийн ялгаатай байдлыг (гадаад төрх, сонирхол, чадвар, хэл, гэр бүлийн орчин гэх мэт) ойлгож, хүлээн зөвшөөрөх

Зорилт

1. Бид бүгд ялгаатай ч адилхан үнэ цэнтэй гэсэн үнэт зүйлийг төлөвшүүлэх
2. Эв найрамдал, бусдад туслах, хүндлэх, хамтран ажиллах чадварыг хөгжүүлэх

Хэрэглэгдэхүүн:

Өөр өөр улсын өөр өөр хүүхдүүдийн зураг

Толь

Нүдний боолт

Тэргэнцэр, таяг, сонсголын төхөөрөмжний зураг

Морин хуур болон өөр улсын хөгжмийн зэмсэг

Өөр өөр хэлээр ярьж буй хүүхдүүдийн бичлэг

Алхамчилсан явц

Алхам 1. Сэдэлжүүлэлт – Танилцах яриа (5 минут)

Багшийн асуулт:

Эдгээр зураг дээр ямар ямар хүүхдүүд байна вэ? (Өөр өөр улсын, өөр төрхтэй хүүхдүүдийн зургийг харуулна.)

Хүүхдүүдийн боломжит хариу:

- Үс нь өөр
- Нүд нь өөр
- Хувцас нь өөр

Багш чиглүүлнэ:

- Тийм ээ, эдгээр хүүхдүүд гадаад төрхөөрөө өөр байна. Гэхдээ бүгдээрээ хөөрхөн байгаа биз?

Багш үргэлжлүүлнэ:

- Одоо бүгдээрээ толинд харцгаая. Яг чамтай ижилхэн харагддаг хүн байна уу?

Түлхүүр үг:
Өөр
Цор ганц

Багшийн дүгнэлт:

- Тийм учраас хүн бүр цорын ганц. Дахин давтагдашгүй.

Анхаарах зүйл:

- Өөрийгөө болон бусдыг шүүмжлэхгүй
- Эерэг уур амьсгал бүрдүүлэх

СЭДАЛГААНЫ САН

Алхам 2. Чадвар, хөгжлийн ялгааг ойлгуулах (5 минут)

Багшийн асуулт:

- Бид бүгд харж чаддаг уу?

Багш тайлбарлана:

- Зарим хүүхдүүд харж чаддаггүй.

Тоглоом:

- Нэг хүүхдийн нүдийг бооно. Нөгөө хүүхэд нь тусална

Тоглоомын дараах асуулт:

- Юм харахгүй байхад ямар санагдсан бэ?

Багш тайлбар:

- Харааны бэрхшээлтэй хүүхдүүд яг ийм байдаг. Тэд тусгай таяг ашигладаг. (Таягтай хүүхдийн зургийг харуулна.)

Ашиглаж болох материал:

Харааны бэрхшээлтэй хүүхдийн талаарх бяцхан түүх:

Өөр өөр улсын хүүхдүүдийн бичлэг:

Сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдүүдэд бэлгийн боловсрол олгох VR хичээл

Нэмэлт тайлбар:

- Зарим хүүхдүүд алхаж чаддаггүй. Тэд тэргэнцэр ашигладаг. Зарим хүүхдүүд сонсож, ярьж чаддаггүй. Тэд гарын хөдөлгөөнөөр ойлголцдог.

Анхаарах зүйл:

- Өрөвдүүлэхгүй
- “Туслах, хүндлэх” ойлголтыг түлхүү өгөх

Алхам 3. Ижил төстэй байдлыг олж харах (4 минут)

Багш асуулт асууна:

- Бид бүгдээрээ юуг ижилхэн хийж чаддаг вэ?

Хүүхдүүдийн боломжит хариу:

- Инээдэг
- Тоглодог
- Найзалдаг

Багш дүгнэнэ:

- Тийм ээ. Бид ялгаатай ч ижил зүйл маш олон.

Алхам 4. Соёл, хэлний ялгааг ойлгуулах (4 минут)

Багш харуулна:

- Морин хуур, гитар (эсвэл өөр хөгжмийн зэмсэг)

Багш асуулт:

- Хоёулаа гоё сонсогдож байна уу?

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Багш тайлбар:

- Хөгжим өөр өөр ч гоё.

Дараа нь:

- Өөр өөр үндэстний хувцас
- Өөр хэлээр “Сайн уу” гэж хэлж буй бичлэг

Багш дүгнэнэ:

- Хүн бүр өөр хэлээр ярьж, өөр хувцас өмсдөг. Энэ нь дэлхийг илүү сонирхолтой болгодог.

Алхам 5. Бататгах – Хүндлэл, туслалцаа (2 минут)

Багш асуулт:

- Хэрвээ найз чинь чамаас өөр байвал чи яах вэ?

Багш дүгнэнэ:

- Бид ялгаатай найзаа хүндэлж, тусалж, хамт тоглох ёстой.

Дүгнэлт (2 минут)

Багшийн асуулт:

- Өнөөдөр бид юу сурсан бэ?

Хүүхдүүдийн хариу:

- Бүгд өөр, бүгд хөөрхөн, бүгд адилхан үнэ цэнтэй.

Багшийн дүгнэлт:

- Бид бүгд ялгаатай ч адилхан чухал.

Эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо

Асран хамгаалагчид өгөх товч мэдээлэл:

Хүүхдүүд: хүмүүс гадаад төрх, чадвар, хэл, соёлоороо ялгаатай гэхдээ бүгд адилхан үнэ цэнтэй гэдгийг сурсан.

Даалгавар 1. “Бид юугаараа өөр вэ?”

Гэр бүлээрээ ярилцаарай:

- Манай гэр бүлийнхэн юугаараа өөр вэ?
- Юугаараа ижил вэ?

Даалгавар 2. Соёлын аялал (гэртээ)

- Өөр орны хоол, хөгжим, хувцасны зураг үзэх
- “Өөр байх нь сонирхолтой” гэдгийг ярилцах

UIH.MN
СУДАЛГААНЫСАН

Эцэг эхэд зөвлөмж

- Ялгаатай хүнийг муулах үг бүү хэрэглэ
- Хүүхэд асуувал энгийн, үнэн зөв хариул
- Хүндэтгэл бол хамгийн чухал үнэт зүйл гэдгийг үлгэрлэ

БАГШИД ЗОРИУЛСАН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Хэл найруулга, харилцаа

- Энгийн, ойлгомжтой үг хэллэг ашиглах
- Биеийн эрхтний нэршлийг ичээлгүй, зөв хэрэглэх
- Хүүхдийг хэзээ ч буруутгахгүй, ичээхгүй

2. Аюулгүй, итгэлтэй орчин бүрдүүлэх

- Хүүхэд асуулт асуух, хариулахад аюулгүй мэдрэмж төрүүлэх
- "Чи буруугүй", "Чи хэлж болно" гэсэн мессежийг байнга дамжуулах

3. Ёс зүйн анхаарах зүйл

- Хүүхдийг хэт дэлгэрэнгүй, насанд нь тохироогүй мэдээллээр ачаалахгүй
- Айдас төрүүлэх үг, жишээ хэрэглэхгүй

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНФЕМНЕТ
ҮНДЭСНИЙ СУЛЖЭЭ

Хүүхэдтэйгээ бэлгийн цогц боловсролын талаар хэрхэн ярилцах вэ?

Эцэг, эхчүүдэд зориулсан энгийн тайлбар

Зөвшөөрөл
Тийм, Үгүй гэж хэлэх

Хил Хязгаар
Бие, орон зай

Мэдрэмж
Тухгүй байгааг анзаарах



МОНФЕМНЕТ

ЗӨВШӨӨРӨЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Хүүхэдтэйгээ ярилцахын өмнө та өөрөөсөө дараах асуултуудыг асуугаад үзээрэй:

Би хүүхдээсээ зөвшөөрөл авч чадаж байна уу?

- Би хүүхдийнхээ өмнөөс шийдвэр гаргахдаа өөрөөс нь асууж байна уу?
- Хүүхдийнхээ зургийг найзууддаа явуулах, сошиал медиагаар хуваалцахдаа өөрөөс нь зөвшөөрөл авдаг уу?
- Аливаа зүйлийн хүүхэдтэйгээ ярилцахдаа асуултаа тодорхой хэлж чадаж байна уу?
- Хүүхдэдээ "Үгүй" гэж хэлэх боломж олгодог уу?
- "Үгүй гэж хэлж болно" гэдгийг урьдчилан хэлж, сонголт өгч байна уу?

Би хүүхдээ сонсож байна уу?

- Хүүхдийнхээ ярианд таслалгүй, дуустал нь сонсож байна уу?
- Аливаа зүйлийг тайлбарлах боломж олгодог уу?
- "Тийм/Үгүй/Одоохондоо үгүй/Зөвхөн ингэж..." гэх бүх хариуг зөвшөөрдөг үү?
- Санал нь өөр байлаа ч хамгаалж, баталгаажуулж чаддаг уу?
- Шахалт, ятгалга, дарамт мэдрүүлэхгүйгээр саналыг нь хүлээн авч чаддаг уу?

Би хүүхдийн хил хязгаар, сонголтыг хүндэлж чаддаг уу?

- Хүүхдийнхээ гаргасан аливаа шийдвэрийг биелүүлж өгдөг үү?
- "Тэврүүлэхгүй" гэвэл үнэхээр зогсож чадах уу?
- "Өчигдөр зөвшөөрсөн шүү дээ" гэж шахдаггүй биз?
- Бодлоо өөрчлөх эрхийг нь хүлээн зөвшөөрдөг үү?
- "Дөнгөж сая тийм гэсэн ч одоо үгүй байж болно" гэж хэлж чаддаг уу?

ПИАМN
ЭНДЭЛГЭЭНЫ САН

Зөвшөөрөл гэж юу вэ?



Зөвшөөрөл нь хүний хүсэл, сонголтыг хүндэтгэх тухай ойлголт.

Зөвшөөрөл гэдэг нь хүмүүс ямар нэгэн зүйлийг хамтдаа хийхийг хүсэж буй талаар ярилцаж, харилцан тохиролцох тухай ойлголт юм.

Хүн аливаа зүйлд зөвшөөрөл өгөхдөө сонголт хийх эрх чөлөөтэй мөн чадавхтай байх ёстой. *"Би үнэхээр хүсэж байна"* эсвэл *"Би бэлэн биш байна"* гэж шударгаар хэлэх мөн бусдын хариуг хүндэтгэх нь зөвшөөрлийн хувьд хамгийн чухал юм.

Зөвшөөрлийн талаар бидний зайлшгүй мэдэх мэдэх ёстой зүйл:

Өөрийн хил хязгаарыг тогтоох

- Өөрт нь юу таатай, юу таагүй байгааг ялгаж сурах.
- Хэн нэгэн биед нь хүрэх эсвэл хамт ямар нэг зүйл хийхийг хүсэхэд "Тийм" эсвэл "Үгүй" гэж хэлэх бүрэн эрхтэй гэдгээ мэдэх.
- Өөрийнхөө хүсэл сонирхлыг бусдад нээлттэйгээр илэрхийлж сурах.

Бусдын орон зайг хүндэтгэх

- Аливаа зүйлд бусдаас заавал зөвшөөрөл авдаг байх.
- Бусдын хариултыг анхааралтай сонсож, "Үгүй" гэсэн шийдвэрийг нь ямар ч нөхцөлгүйгээр хүндэтгэх.

Зөвшөөрлийн дүрэм

Асуу. Сонс. Хүндэл

- **Сайн дурын:** Та аливаа зүйлд "тийм" гэж зөвшөөрч байгаа бол энэ нь сайн дурын байх. Ямар нэг ятгалга, дарамтаар бус байх.
- **Бүрэн мэдээлэлтэй:** Юунд зөвшөөрч буйгаа бүрэн мэдэх. Эерэг, сөрөг талыг нь сайн мэдэж байх.
- **Тодорхой:** Ямагт нэг зүйлд зөвшөөрч буй нь бүх зүйлд зөвшөөрсөн гэсэн үг биш. Энэ нь тухайн нөхцөлд л зөвшөөрч буй гэдгийг тодорхой ойлголцох.
- **Эргэлзээ, тээнэгэлзээгүй:** Хэн нэгнийг гомдоохоос зайлсхийх, айх байдлаар "Тийм" гэх нь үнэн, бодит зөвшөөрөл биш. Аливаа зөвшөөрөл өгөхдөө түүндээ баяртай, дуртай байх ёстой.
- **Шийдвэрээ өөрчлөх боломжтойгоо ухамсарлах**: Өмнө нь "Тийм" гэж зөвшөөрсөн ч дараагийн тохиолдолд "Үгүй" гэж хэлэх нь хэвийн зүйл гэдгийг ойлгох.

ТОН.MN
СУДАЛГААНЫ САН

Зөвшөөрлийн талаар баталгаажуулж дараах асуултын дагуу хүүхдүүдтэйгээ ярилцаарай

Энэ зөв үйлдэл мөн үү? Яагаад

1. Анги дээрээ хөгжилтэй царай гаргаж байх үед чинь ангийн чинь хүүхэд зураг авчээ. Тэгээд чамаас асуулгүйгээр сошиал медиад байршуулчихав.

Энэ зөв үйлдэл мөн үү? Яагаад

2. Танай ангид шинэ хүүхэд ирсэн. Найз чинь "Чи тэр хүүхэд дээр очиж яриа өд л дөө" гэж шахав. Чамд тухгүй байсан ч найзыгаа гомдоохгүйн тулд зөвшөөрлөө.

Хүүхдийнхээ хариуг зөв, буруу гэж шүүлгүй, анхааралтай сонсоорой

Хүүхэдтэйгээ хил хязгаарын талаар ярилцах нь

Эцэг, эхчүүдэд зориулсан мэдээлэл

Зөвшөөрөл
Тийм, Үгүй гэж хэлэх

Хил Хязгаар
Бие, орон зай

Мэдрэмж
Тухгүй байгааг анзаарах



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хил хязгаарын талаар хүүхэдтэйгээ ярилцъя!

Хүүхэдтэйгээ ярилцахаас өмнө та доорх асуултуудад хариулаарай!

Би хүүхдийнхээ бие махбодын хил хязгаарыг мэддэг үү?

- Хүүхэд маань “Үгүй” гэж хэлэхэд би тайван хүлээж авдаг уу?
- Хүүхэд маань бодлоо өөрчилбөл “За ойлголоо” гэж хэлж чаддаг уу?
- Хүүхдийн хувийн орон зайг (өрөө, биед нь хүрэх, эд зүйл) зөвшөөрөлтэй хүндэлж байна уу?

Би хүүхдийнхээ сэтгэл зүйн хил хязгаарыг сонсож байна уу?

- Хүүхэд таагүй мэдрэмж төрж байгаагаа хэлэхэд "Зүгээр ээ," гэж няцаахгүйгээр хүлээж авч чаддаг уу?
- Хүүхдийнхээ өөрийн гэсэн үзэл бодол, хүсэл сонирхлыг нь "Минийхээс өөр" байлаа ч хүндэтгэж чаддаг уу?
- Хүүхдийнхээ мэдрэмжийг "Зөв эсвэл буруу" гэж шүүхгүйгээр байгаагаар нь хүлээн авч чаддаг уу?

Би хүүхдэдээ хил хязгаар тогтоох боломж олгодог уу?

- Хүүхэд маань өнөөдөр "За" гэсэн зүйлдээ маргааш "Үгүй" гэж бодлоо өөрчлөхөд би түүний сонголтыг хүлээн зөвшөөрдөг үү?
- Хүүхдийнхээ "Аюулгүй байдлын тойрог"-т хэн байхыг өөрөөр нь шийдүүлж чаддаг уу?
- Хүүхэд минь өөрийнхөө хил хязгаарыг хамгаалж байгааг "Зөрүүд зан" гэж харахын оронд "Өөрийгөө хамгаалах чадвар" гэж дэмждэг үү?

Хил хязгаар гэж юу вэ?

"Хил хязгаар" гэдэг нь бидний бие махбодын аюулгүй байдал, сэтгэл зүйн тайван байдлыг хамгаалах **үл үзэгдэх зурвас** юм. Энэ нь өөрийгөө хамгаалах зорилгоор бие махбод, сэтгэл санаа болон хувийн орон зайн эргэн тойронд татсан **"Өөрийн дүрэм"** гэж ойлгож болно.

UIH.MN
СЭДАЛГААНЫ САН

Хил хязгаарын талаар бидний зайлшгүй мэдэх ёстой зүйлс:

Өөрийн хил хязгаарыг ойлгож тогтоох

- Өөрт чинь юу таатай, таагүй байгааг ялгаж сурах.
- Хэн нэгэн биед чинь хүрэх эсвэл хамт ямар нэг зүйл хийхийг хүсэхэд "Тийм" эсвэл "Үгүй" гэж хэлэх бүрэн эрхтэй гэдгээ мэдэх.
- Өөрийнхөө хүсэл сонирхлыг бусдад нээлттэйгээр илэрхийлж сурах.

Бусдын хил хязгаарыг хүндэтгэх

- Аливаа зүйлд бусдаас заавал асууж, зөвшөөрөл авдаг байх.
- Бусдын “Үгүй” гэсэн хариуг ямар ч нөхцөлгүйгээр хүлээн зөвшөөрөх.
- Хэн нэгний бодлоо өөрчлөх эрхийг хүндэтгэх
- Хил хязгаарыг давахгүй байх нь хүндлэл гэдгийг ойлгох.

Хил хязгаарын дүрэм

1. "ҮГҮЙ" гэж хэл
2. Түхгүй байвал холд
3. Итгэдэг насанд хүрсэн хүнд хэл

АЮУЛГҮЙ ХАРИЛЦАА

Эрүүл харилцаа тогтоодог хүмүүс чиний хил хязгаарыг үргэлж хүндэтгэдэг

- Чамд хүрэхээсээ өмнө *(тэврэх, гар барих)* заавал асуудаг.
- Чамайг анхааралтай сонсож, тав тухтай мэдрэмж төрүүлдэг.
- Чиний "Үгүй" гэсэн шийдвэрийг ямар ч нөхцөлгүйгээр хүлээн авдаг.

АНХААРУУЛАХ ДОХИО

Дараах тохиолдол нь чиний хил хязгаарыг давж буйг илтгэнэ:

- Хэн нэгэн чиний мэдрэмжийг үл тоомсорлох.
- Ямар нэгэн зүйл хийлгэхээр дарамтлах, шахах.
- Чамд айдас төрүүлэх эсвэл тухгүй байдалд оруулах.
- Чиний хүсэл зоригийн эсрэг, айдас төрүүлэх байдлаар биед чинь хүрэх.

Хил хязгаарын 5 хүрээ

"Хүүхдэдээ ойр дотнын хүмүүс болон холын танилуудтайгаа хэрхэн, зөв, хүндэтгэлтэй харилцах ёстой талаар нээлттэй ярилцаарай."



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН